



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/654

Есөнбулаг

Дүрэм, бүтэц, орон тоог шинэчлэн  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалт, Засгийн газрын 2022 оны "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" 487 дугаар тогтоол, 2023 оны "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дүгээр тогтоол, "Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 312 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 41 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дүрмийг нэгдүгээр, бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Орон нутгийн өмчийн газрын шинээр батлагдсан бүтэц, орон тоонд багтаан шаардлагатай төсвийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгаж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/418 дугаар захирамж, 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/442 дугаар захирамж, 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/659 дүгээр захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20-дугаар  
сарын 6-ны өдрийн 65-дугаар  
захирамжийн 1-р хавсралт

**АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Аймгийн Орон нутгийн өмчийн газар (цаашид "газар" гэнэ) нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын хэрэгжүүлэх Төрийн болон орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлогыг аймаг, сумын хэмжээнд зохион байгуулах, чиг үүрэг бүхий аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн газар мөн.

1.2. Орон нутгийн өмчийн газар нь үйл ажиллагаандаа Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авлигын эсрэг хууль, Компанийн тухай хууль, Иргэний тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг баримтлан ажиллана.

1.3. Энэхүү үлгэрчилсэн дүрэмд нийцүүлэн Орон нутгийн өмчийн газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг байгууллагын хамт олны хурлаар хэлэлцүүлэн, баталж, мөрдүүлнэ.

**Хоёр. Орон нутгийн өмчийн үндсэн үйл ажиллагаа**

2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хууль, тогтоомж, Засгийн газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, биелэлтэд хяналт тавина.

2.2. Нутгийн удирдах байгууллагаас баримталж буй бодлогын хүрээнд орон нутгийн өмчийн бодлогыг хэрэгжүүлнэ.

2.3. Орон нутгийн өмчийг хувьчлалын орлого болон түрээсийн төлбөрийн төслийг боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлэн, аймгийн ИТХ-аар баталсан нэр бүхий орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

2.4. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг хувьчилсан ажлын дүнг эрх бүхий байгууллагад тайлагнана.

2.5. Орон нутгийн өмчит байгууллага, аж ахуйн нэгжүүдэд эд хөрөнгийн анхан шатны бүртгэл хөтлөх, өмчийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтын талаар эрх бүхий албан тушаалтанд шаардлага тавьж, биелэлтийг хангах ажлыг зохион байгуулж хяналт тавина.

2.6. Орон нутгийн өмчийн бүртгэл, судалгааг батлагдсан маягт, журмын дагуу бүтэн жилээр гаргаж Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Үндэсний статистикийн хороонд хүргүүлнэ.

2.7. Орон нутгийн өмчийг хуульд нийцүүлэн зориулалтын дагуу үр ашигтай ашиглуулах, эзэмшилт ашиглалтгүй байгаа өмчийг хуулийн этгээдэд эзэмшүүлэх, өмчийг зүй бусаар ашиглах, завших, элдэв хэлбэрээр үрэгдүүлэх явдлыг таслан зогсоох арга хэмжээ авах, уг ажилд эрх бүхий мэргэжлийн хэлтэс, албадыг татан оролцуулж хамтран ажиллана.

2.8. Орон нутгийн өмчит хуулийн этгээд хоорондын харилцаа нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлаар батлагдсан журмын дагуу зохицуулагдана.

2.9. Орон нутгийн өмчийн газар нь дор дурдсан асуудлыг аймгийн Засаг даргаар уламжлуулан Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, хэрэгжилтийг ханган ажиллана. Үүнд:

2.9.1. Орон нутгийн өмчийг хувьчлах бодлого, чиглэл, хувьчилж үл болох орон нутгийн өмчийн жагсаалтын санал боловсруулах /Хувьчлах орон нутгийн өмчийн эд хөрөнгийн жагсаалтыг батлах асуудлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай зөвшилцөн шийдвэрлэнэ/

2.9.2. орон нутгийн нийтийн зориулалттай өмчид хамаарах эд хөрөнгийн жагсаалт, түүнийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журам боловсруулах

2.9.3. орон нутгийн өмчийн эд хөрөнгийг нийтийн зориулалттай өмчид, эсхүл өөр өмчид шилжүүлэх талаар санал боловсруулах

2.9.4 орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн эд хөрөнгө, хувьцааны өөрт ногдох хувийг тодорхойлох, үндсэн хөрөнгөнд хамаарах үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгийн эзэмших, ашиглах, захиран зарцуулах журам боловсруулах

2.9.5. орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах, бусдад шилжүүлэх, шинээр олж авах төлөвлөгөө, ашиглах, актлах журам боловсруулах

2.9.6. орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах санал боловсруулах, хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах

2.9.7. орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгөөс бусад өмчийн этгээдтэй хамтран хуулийн этгээд байгуулах, хөрөнгө оруулах, оруулсан хөрөнгөө татан авах талаар санал боловсруулах

2.9.8. орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам боловсруулах

2.9.9 орон нутгийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалт, цалин хөлсний норм, нормативыг тухайн ТУЗ-өөр дамжуулан тогтоох, санал боловсруулж шийдвэрлүүлэх

2.9.10. орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад тавих хяналт шалгалтыг зохион байгуулах талаар санал боловсруулах, орон нутгийн өмчийн тооллогыг явуулж дүнг нэгтгэн Засаг дарга, ИТХ хуралд танилцуулах

2.9.11 Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлт хийх

### **Гурав. Зохион байгуулалтын бүтэц, үр дүнгийн гэрээ байгуулах**

3.1. Газар нь Орон нутгийн өмчийн чиглэлээр мэргэшсэн дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэнтэй байна. Мөн газарт үйлчилгээний ажилтан ажиллуулж болно.

3.2. Газрын даргыг аймгийн Засаг дарга, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.

3.3. Газрын ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүдийг Төрийн албаны тухай хууль тогтоомж болон ажлын байрны тодорхойлолтод тавигдсан шалгуурын дагуу сонгон шалгаруулж, газрын дарга томилж, чөлөөлнө.

3.4. Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу Орон нутгийн өмчийн газрын дарга Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан, батлуулж түүний үр дүн мэргэшлийн түвшинг Засаг даргаар үнэлүүлнэ. Ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод тусгагдсан чиг үүрэг болон хууль тогтоомж, нэгжийн хөдөлмөрийн дотоод журмаар ногдуулсан үүрэг, нэгжийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт тусгагдсан хариуцах ажлын чиглэлийг үндэслэнэ.

3.5. Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу газрын дарга нь ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүдийн Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан, батлуулж үнэлнэ.

### **Дөрөв. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон Орон нутгийн өмчийн газрын хоорондын харилцаа**

4.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааг удирдан чиглүүлж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй байна. Үүнд:

а/Орон нутагт байгаа төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалтад хяналт тавих.

б/ Өмчийн асуудлаар хамтарч ажиллах, харилцан мэдээлэл солилцох, орон нутгийн өмчийн талаарх шаардлагатай мэдээллийг гаргуулан авах

### **Тав. Газрын үндсэн чиг үүрэг**

5.1.1. Орон нутгийн төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон аймгийн Засаг даргыг бүх талын мэдээллээр хангах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;

5.1.2. Монгол Улсын Засгийн газар, Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас гаргаж буй шийдвэрийн хэрэгжилтийг хангах, сурталчлах ажлыг зохион байгуулах.

5.1.3. Газрын ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулах, ажлын үр дүнг харгалзан шагнаж урамшуулах.

5.1.4. Санхүүгийн нөөцөө бодитой төлөвлөж, түүний гүйцэтгэлийн тайланг шаардлагын дагуу үнэн зөв гаргаж, холбогдох байгууллагад хуулиар тогтоосон хугацаанд мэдээлж тайлагнах;

5.1.5. Газрын дарга нь үйл ажиллагааныхаа үр дүнг аймгийн Засаг даргад тайлагнах, үр дүнгийн гэрээгээ дүгнүүлэх;

#### **Зургаа. Санхүү, бүртгэлийн тайлан**

6.1 Орон нутгийн өмчийн газар нь санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

6.2 Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг газрын дарга, нягтлан бодогч нар хариуцна.

6.3 Санхүүгийн тайланд дараах зүйлсийг хамруулан ойлгоно. Үүнд:

6.3.1 Баланс

6.3.2 Орлого үр дүнгийн тайлан

6.3.3 Мөнгөн гүйлгээний тайлан

6.3.4 Өмчийн өөрчлөлтийн тайлан

6.3.5 Хуримтлагдсан ашгийн тайлан

#### **Долоо. Хууль, дүрэм зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

7.1 Энэхүү дүрмийг зөрчигчдөд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

#### **Найм. Бусад**

8.1 Энэ дүрэмд тусгагдаагүй бусад асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол улсын Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

8.2 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааг удирдан чиглүүлж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлнэ.

Аймгийн Засаг даргын 2014 оны  
11 сарын 6-ны өдрийн 64 дугаар  
захирамжийн 9-р хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаалын нэршил	Албан тушаалын төрөл	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Орон тоо
1	Орон нутгийн өмчийн газрын дарга	Удирдах	Ахлах түшмэл, ТЗ-4	1
2	Өмчийн удирдлага, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-8	1
3	Өмчийн бүртгэл ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-8	1
4	Өмчийн удирдлага төлөөлөл хариуцсан мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-9	1
5	Өмчийн хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-9	1
6	Хөрөнгийн бүртгэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-9	1
7	Өмчийн ашиглалт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-9	1
8	Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-9	1
9	Хууль, хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-9	1
10	Нягтлан бодогч	Гүйцэтгэх	ТҮ-8	1
11	Архив, бичиг хэргийн эрхлэгч	Гүйцэтгэх	ТҮ-5	1
12	Нярав, жолооч	Гүйцэтгэх	ТҮ-5	1
	Нийт			12